



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/158

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.7 дугаар зүйл, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12-р сарын 02 өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.


1.Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбарын нэгдсэн хяналт шалгалт хийх, хууль бус мод бэлтгэл, ойн нөхөн сэргээлт, хууль бусаар ашигт малтмал ашиглах, зохисгүй газар ашиглалт, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, хог хаягдал, аялал жуулчлал, ус, рашаан, ан амьтан хамгаалах, хяналт тавих ажилд 30,000,000.0 (гучин сая) төгрөг зарцуулсугай.

2.Ойн мэргэжлийн байгууллагуудын 2022 оны өөрийн хөрөнгөөр хийх ойжуулалтыг аймагт татан төвлөрүүлсэн орлогын он дамжсан үлдэгдлээс гаргахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал) -д үүрэг болгосугай.

3.Батлагдсан зардлыг холбогдох данснаас гаргаж хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, баримтын бүрдлийг ханган, тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч (Д.Лхамжаргал) үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн засаг даргын орлогч (М.Хуягбаатар) –д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ.